

СОЛОНГОСЫН ХОЙГ ДАХЬ ОРОСЫН АШИГ СОНИРХОЛ

Д.Аюуш*

***Abstract:** Russia always had strategic and geopolitical interest for Korean peninsula. Russia has been sougning for an exit to the Asia-Pacific region through the regions comprising the territory of China and the Korean peninsula, which are between the Russian border and ports along the shores of the South-East Asia. A new stage in the relations of the Russian Federation with the two Koreas can be correlated and with the change of the political elites in both States. Russia and North Korea have very specific geopolitical needs. For Russia, North Korea is a strategic buffer separating it from the United States and Japan. Partnership between Russia and the North Korea intensifies its possibilities in relations with South Korea and Japan in matters of the economy, and with the United States in security matters (such as NATO expansion and missile defense).*

North Korea continue to serve for Russia as an economic corridor for entering the markets of Northeast Asia, as well as a strategic buffer separating it from long-time rivals. From the Russian side underlined the indispensability of political-diplomatic solutions available Korean peninsula issues within the framework of the six-party negotiating process, as well as the need to avoid steps that could lead to increased conflict potential in the region. The Ministry of Foreign Affairs of the Russian Federation condemned the DPRK tests of the hydrogen bomb, noting that, if the test is confirmed, this will be a flagrant violation of international law.

***Key words:** Korean Peninsula, Russian Geopolitics, Korean War, Debt of North Korea, Experiment of Nuclear Weapon, Economic Corridor*

* * *

Оросууд XIX зууны үед оросын барааны урсгал Хятад, Солонгосын умард нутаг дээвсгэрээр дамжин ЗӨА руу гарахаас шалтгаална гэдгийг ойлгож эхэлжээ. Иймээс 1897-1903 онд Оросын эзэнт гүрэн Манжуурт 2450 км урттай төмөр замын сүлжээг барихад асар их хөрөнгийг зарцуулсан байдаг. Энэ замаа хяналтандаа байлгахын тулд Орос нь байнга Япон, Хятад хоёртой зөрчилдөөнтэй байв.

Өнөө цагт ОХУ хоёр Солонгостой чөлөөт эдийн засгийн харилцаа тогтоосноор Шар тэнгис болон Дорнод-Хятадын тэнгис рүү гарах замаа өргөжүүлэх боломжтой болоод байна. 1989 онд ОХУ, БНХАУ хоёр харилцаагаа хэвийн болгоод, хамтын ажиллагаагаа амжилттай хөгжүүлсээр байна. Харилцан сайн ойлголцож чадвал оросууд ЗӨА руу Манжуураар дамжин гарах замаа сэргээж чадна.

Солонгосын хойг дахь ямар ч зөрчилдөөн байсан Оросын Алс Дорнодод цэрэг, улс төр, эдийн засгийн аюул заналхийлэл шууд үүсгэнэ. Гэтэл сүүлийн 60 гаруй жилийн туршид Солонгосын хойг дээр хоёр харилцан дайсагналцсан улс байгаагаас болж түгшүүрийн голомт байсаар байна.

* МУИС, ОУХНУС-ийн Зөвлөх багш, Доктор (Ph.D)

БНСУ (38-р өргөрөгөөс урагш оршдог) байгуулагдсан өдрийг албан ёсоор 1948 оны 8-р сарын 15-ны өдөр гэдэг, БНАСАУ-ыг (38-р өргөрөгөөс хойш байдаг) 1948 оны 9-р сарын 9-ний өдөр тунхагласан байдаг. 1945 оны 9, 10-р сард Алс Дорнодыг чөлөөлөх Зөвлөлт-Америкийн хамтын ажиллагааны явцад уг хойг хоёр хэсэгт хуваагдсан түүхтэй.

Анхандаа хойгийг дипломат яриа хэлэлцээний замаар нэгтгэхээр төлөвлөж байсан боловч, олон улсын харилцаанд хоёр туйлт тогтолцоо буй болж, хүйтэн дайн эхэлснээр үүнд саад учирсан юм.

XX зууны хамгийн их цус асгаруулсан дайны нэг болсон 1950-1953 оны Солонгосын дайн нь хойгийг хоёр хэсэгт хуваагдсаныг бүрмөсөн бэхжүүлсэн юм. Солонгосын дайн нь цөмийн дайн болж хувирах аюултай анхны мөргөлдөөн байв. Энд нэг зүйлийг онцлон хэлэхэд, өнөөг хүртэл хоёр улсын хооронд энхийн гэрээ байгуулаагүй, зөвхөн гал зогсоох түр хэлэлцээр л байдаг. XX зууны 90-ээд оны эхэн үеийг хүртэл Солонгосын хойгийн нутаг дэвсгэр дээр томоохон гүрнүүдийн харилцааг тэнцвэржүүлсээр байв: Бүгд Найрамдах Солонгос Улсын улс төр, эдийн засаг, цэргийн холбоотон нь АНУ, хожим нь Япон болсон. Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсад Зөвлөлт Холбоот Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улс хоёр тус, дэмжлэг үзүүлж байв.

1980 оны дунд үеэс ЗСБНХУ-ын хоёр Солонгосын хувьд явуулж ирсэн бодлого өөрчлөгдөж эхэлсэн. ЗХУ нь БНАСАУ-аас аажмаар холдож эхэлсэн, харин үүнээс өмнө буюу бүр 1960-аад оноос хойш тодорхой үзэл суртлын зөрөлдөөнөөс болж хоёр улсын харилцаа хэвийн бус байв.

Өмнөд Солонгостой юуны өмнө эдийн засаг, соёлын салбарын харилцаагаа хэвийн болгох хандлага буй болсон. 1990 оны 9-р сарын 30-ны өдөр ЗСБНХУ ба БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосон юм. ЗСБНХУ задарсны дараа Оросын гадаад бодлогод ноцтой өөрчлөлтүүд гарав. Тухайлбал, хуучны үзэл суртлаас татгалзах үйл явц үргэлжилснээр ЗСБНХУ уламжлалт түншүүдээсээ, үүний дотор Алс Дорнод дахь түншээсээ харилцаагаа таслахад хүрсэн юм. Эдийн засгийн реформ эхэлсэнтэй зэрэг Оросын хувьд гадаадын хөрөнгө оруулалт хийх нэн шаардлагатай болсон аж. 1990-ээд оны эхэн үед Өмнөд Солонгос эдийн засгийн хөгжлийнхөө оргил үедээ байсан учраас ОХУ-ын хувьд боломжийн хөрөнгө оруулагч бөгөөд Оросын цэргийн техник, түүхий эдийг борлуулах зах зээл болох талаасаа сонирхлыг ихээхэн татаж байв. Ийнхүү 1990-ээд оны эхний хагасад Өмнөд Солонгостой хамтын ажиллагаагаа хүчтэй өргөжүүлж, Хойд Солонгостой улс төр, эдийн засаг, цэргийн харилцаагаа зогсоосон түүхтэй юм.

ОХУ, БНСУ-ын хоорондын харилцаа төрийн дээд түвшинд хөгжих болсноор 1992 оны 11-р сард ОХУ-ын Ерөнхийлөгч Б.Ельцин, БНСУ-ын Ерөнхийлөгч Ро Дэу нар “Хоёр улсын хоорондын харилцааны үндсийн тухай гэрээ”-нд гарын үсэг зурав. Хоёр талын тохиролцсоны дагуу Сибирь, Алс Дорнодын байгалийн нөөц баялгийг олборлоход хамтран ажиллахаар болов.

1995 онд ОХУ 1961 онд байгуулсан “ЗСБНХУ, БНАСАУ-ын хоорондын найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслалцах тухай гэрээ”-г сунгахаас татгалзсан бөгөөд шинэ гэрээний төслийг хэлэлцэх саналыг Хойд Солонгосын талд тавьсан боловч, 1990-ээд оныг дуустал уг төсөл нь боловсруулах түвшиндээ явсаар байв. Үүний зэрэгцээ Оросын талаас Хойд Солонгост үзүүлж ирсэн эдийн засаг, цэргийн тусламжаа зогсоосон юм. Энэ бодлого нь үндсэндээ Солонгосын хойг дахь Оросын байр суурийг сулруулж, улмаар Солонгосын асуудлыг зохицуулах, уг хойгийг нэгтгэх үйл явцад идэвхтэй оролцож ирсэн улс орнуудын бүлэглэлээс ОХУ-ыг шахан гаргахад хүргэсэн юм.

1993-1994 онд Хойд Солонгосын плутонийн цөмийн хөтөлбөрийг зогсоох зорилгоор дарамт үзүүлэхтэй холбоотойгоор үүссэн “цөмийн хямрал” Солонгосын хойг дахь ОХУ-ын байр суурийг улам сулруулсан юм. ЗХУ-ын идэвхтэй дэмжлэгтэйгээр Хойд Солонгосын цөмийн хөтөлбөрийг үүсгэсэн түүх 1950-иад оны дунд үеэс үүдэлтэй. 1956-гаас 1990-ээд оны эхэн хүртэлх хугацаанд ЗХУ-ын Дубна дахь Цөмийн судалгааны нэгдсэн хүрээлэнд Хойд Солонгосын 250 мэргэжилтнийг бэлтгэсэн байдаг. 1959 онд ЗСБНХУ ба БНАСАУ-ын хооронд цөмийн судалгааны салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулагдсан бөгөөд хожим нь БНХАУ, БНАСАУ-ын хооронд бас тийм хэлэлцээр байгуулжээ. 1965 онд Енбенд Хятад, ЗХУ-ын тусламжтайгаар анхны судалгааны цөмийн реакторыг ажиллуулж, мөн Цөмийн физикийн эрдэм шинжилгээ судалгааны хүрээлэнг байгуулжээ. ЗХУ болон БНХАУ бас нэгэн цөмийн гүрэн байгуулагдахыг хүсээгүй учраас БНАСАУ-д цөмийн судалгаа хөгжих үйл явцыг хяналтандаа байлгахыг эрмэлзэж байв. 1977 онд Хойд Солонгос ЗХУ-ын шахалтаар цөмийн байгууламжуудаа МАГАТЭ-гийн ажиглагчдаар шалгуулахыг зөвшөөрсөн бөгөөд 1985 онд Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай гэрээ (ЦЗҮДГ) -нд нэгдэн орсон юм. Гэсэн хэдий ч, 1980-аад оны сүүлчээр Хойд Солонгос анхны хялбар хийцийн цөмийн төхөөрөмжийг бүтээсэн гэж үздэг. Түүнийг харин цохилт өгөх газарт нь хүргэх хэрэгсэл огт байхгүй байсан боловч энэ нь ноцтой аюул занал учруулж болзошгүй байв.

1993 онд Хойд Солонгос ЦЗҮДГ-нээс гарснаа зарласан нь анхны цөмийн хямралд хүргэсэн түүхтэй. Үүнийг зохицуулахын тулд ОХУ нь АНУ-ын санаачилгаар Хойд Солонгост дарамт шахалт үзүүлэхээр нэгдсэн улсуудын байр суурийг хэрэг дээрээ дэмжсэн юм.

БНХАУ-ын тус дэмжлэгтэйгээр АНУ, БНАСАУ-ын хооронд дипломат яриа, хэлэлцээний шугамаар уг хямралыг зохицуулсан. 1994 онд АНУ тэргүүтэй олон улсын консорциум “КЕДО”-гийн хүчээр Цөмийн цахилгаан станц барьж өгч, оронд нь БНАСАУ-ын цөмийн хөтөлбөрийг царцаах тухай хэлэлцээрийг байгуулсан бөгөөд хожим нь “КЕДО” ажлаа зогсоосон юм. АНУ ба БНХАУ дипломат ажиллагаа амжилттай явуулсны улмаас эдгээр хоёр улсын солонгосын асуудлаар гүйцэтгэж буй үүрэг ихээхэн өссөн байхад Оросын нэр хүнд улам ихээр унасаар байв.

1990 оны хоёрдугаар хагасаас Оросын Солонгост хандах гадаад бодлогод өөрчлөлт гарч эхэлсэн. Юуны өмнө энэ нь Оросын гадаад бодлого хариуцсан яамны удирдлага солигдож, Гадаад хэргийн яамны сайдаар Е.Примаковыг томилсонтой холбоотой байв. 1996 оноос БНАСАУ-тай дипломат харилцаагаа аажмаар сэргээж эхэлсэн нь хоёр талын харилцаанд эергээр нөлөөлж эхэлжээ. Харин Өмнөд Солонгостой тогтоосон харилцаа зогсонги байдалд орсон аж. 1997 оны ЗӨА-ийн санхүүгийн хямрал болон 1998 оны Оросын төлбөрийн чадварын хямрал зэрэг нь хоёр улсын эдийн засгийн харилцааг үндсэндээ царцанги байдалд оруулсан юм. Хоёр Солонгостой харилцахад тодорхой хэмжээний тэнцвэртэй байдал бий болжээ.

ОХУ болон хоёр Солонгосын харилцааны шинэ үе шат уг хоёр улсын дээд удирдлагад гарсан өөрчлөлтүүдтэй холбоотой байв. Анх байгуулагдсан цагаас хойш улс орноо удирдаж ирсэн СХН-ын ТХ-ны ЕНБ-ийн дарга, БНАСАУ-ын Ерөнхийлөгч Ким Ир Сен 1994 онд нас барснаас хойш 1997 оныг хүртэл улс дотроо гашуудалтай байж, Ким Ир Сений хүү Ким Чен Ир ил гаралгүй, улсаа далдуур удирдсаар байв. 1997 оны дундуур эцгийнхээ дурсгалын гашуудлыг дууссаны дараа шинэ удирдагчийн үйл ажиллагаа идэвхжиж эхэлсэн. Үүний зэрэгцээ 1997 оны сүүлээр Өмнөд Солонгосын шинэ Ерөнхийлөгчөөр ардчиллын төлөөх нэрт зүтгэлтэн бөгөөд хүний эрхийг хамгаалагч Ким Тэжун сонгогдов.

Түүний БНАСАУ-тай харилцаагаа хэвийн болгож, улмаар нэгтгэхэд чиглэсэн “нарны дулаан элч” бодлого нь зөвхөн БНАСАУ-тай төдийгүй, мөн ОХУ-тай харилцахад эерэг нөлөө үзүүлсэн юм. Ким Тэжун солонгосын асуудлыг зохицуулах үйл явцад Оросын оролцоо чухал болохыг онцолж байв. Ийнхүү 1990-ээд оны сүүлээр хоёр Солонгостой харилцахад тэнцвэртэй байдлыг аажмаар сэргээж эхэлсэн юм.

БНАСАУ-тай харилцаагаа хэвийн болгоход ОХУ-ын засгийн эрхэнд В.Путин гарч ирсэн нь эерэг хүчин зүйл болсныг тэмдэглэх нь зүйтэй. Тэрбээр Хойд Солонгостой сайн хөршийн харилцаа тогтоохын чухлыг нэг бус удаа онцлон хэлж байв.

Хуучин гэрээнээсээ тагалзсанаас хойш таван жилийн дараа 2000 онд ОХУ, БНАСАУ-ын хооронд шинээр “Найрамдал, сайн хөршийн харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”-нд гарын үсэг зурсан юм. Мөн 2000 ондоо В. Путин Хойд Солонгост албан ёсны айлчлал хийх явцад “Хамтарсан тунхаглал”-д гарын үсэг зуржээ. 2001 оны зун БНАСАУ-ын тэргүүн Ким Чен Ир ОХУ-д хариу айлчлал хийж, “Москвагийн тунхаглал”-д гарын үсэг зурсан нь хоёр улсын харилцаанд чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм. 2000 оноос хойш хоёр улсын хоорондын эдийн засаг, цэргийн хамтын ажиллагаа сэргээж эхэлсэн юм. АНУ-ын Зүүн Өмнөд Ази дахь зарим түншүүд Америкийг шүтдэгийн нэгэн адил Хойд Солонгос Оросод илүү тааламжтайгаар ханддаг.

Үүний зэрэгцээ Хойд Солонгос Зүүн Хойд Азийн асуудлыг шийдвэрлэхэд Оросын гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх таатай боломжийг олгож байгаа юм.

Хэдийгээр ЗХУ задарч, 1990-ээд онд оросууд нэлээд анхааралгүй, хайнга хандаж байсан ч гэсэн Хойд Солонгос ОХУ-тай харилцаагаа сэргээх гэсэн оролдлогоосоо хэзээ ч татгалзаж байсангүй. Хойд Солонгосын улс төр, цэргийн дээд зиндааны удирдагчид нь улс төр, эдийн засаг, соёлын салбарууд болон цэргийн асуудлаар ОХУ-тай харилцаагаа хөгжүүлэхийг байнга уриалж ирсэн байна. Арван жилийн дараа буюу Оросын Ерөнхийлөгч В.Путиныг төр, засгийн эрхэнд гарч ирснээр тэд нар нааштай хариуг авч эхэлжээ. 2000 онд БНАСАУ-д хийсэн В.Путины айлчлал нь урьд өмнө нь зөвлөлтийн туслалцаа болон техникийн тусламжаар аж үйлдвэрийн газрууд болон бусад барилга, байгууламжийг нь бий болгож өгсөн хуучин түншүүддээ ихээхэн анхаарал, ач холбогдол өгч буйг нь харуулав. Ийнхүү 2001 онд ОХУ ба БНАСАУ урьдын харилцан туслалцах гэрээнийхээ оронд сайн хөршийн харилцааны тухай хэлэлцээртэй болов.

2009 оны 5-р сард Хойд Солонгос цөмийн туршилт хийснийхээ дараа Өмнөд Солонгосын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэхээр заналхийлсэн тул ОХУ, АНУ хоёр нь НҮБ-ийн АЗ-ийн бусад байнгын гишүүдийн хамт Хойд Солонгосын эсрэг авах НҮБ-ийн шинэ хоригийг санал нэгтгэжээ дэмжсэн юм .

2014 оны 5-р сард ОХУ БНАСАУ-ын хуучин ЗХУ-ын үед хуримтлагдсан 11 тэрбум ам.долларын өрийн 10 тэрбумыг нь тэглэсэн юм. Хойд Солонгосын өрийн 90 хувийг (дашрамд хэлэхэд, Монголын өрийн 98 хувийг тэглэсэн) хүчингүй болгосны үр дүнд оросууд тус улсын дэд бүтцийг хөгжүүлэх гол гол төслүүдэд хувь эзэмшин оролцохоор болсон юм.

ОХУ Солонгосыг дамнасан төмөр замыг барих, хийн хоолой тавих, эдийн засгийн онцгой бүс байгуулах, боловсролыг хөгжүүлэхэд хөрөнгө оруулна. Хойд Солонгостой эдийн засгийн харилцаатай байх нь аль хэдийн мартагдаж, орхигдсон Алс Дорнод ба Сибирийн бүс нутгийг хөгжүүлэх В.Путиний төлөвлөгөөнд болон Хятадын болон Зүүн Азийн эрдсийн зах зээлд гарахын тулд ОХУ-ын экспортыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм.

Хойд Солонгос болон ОХУ-ын Алс Дорнод нь ашигт малтмал ихтэй боловч ЗХА-ийн хамгийн тусгаарлагдсан, хөгжлөөр дорой бүс нутаг гэж тооцогддог. Харин эсрэгээрээ, Хятад, Япон, Өмнөд Солонгосыг эдийн засгийн хүчирхэг төвүүд гэж үздэг. Хойд Солонгост томоохон ашигт малтмалын орд газрууд байдаг боловч тэнд түлш болон байгалийн хий байхгүй юм. Ийм учраас хойд солонгосчууд Сибирээс Хятад ба Өмнөд Солонгос руу татах хийн хоолойноос гарах ашгийг хүртэхийг хүсч байгаа аж. Уг төслүүдийн талаарх яриа нэлээн эртнээс яригдаж байгаа юм.

Үүний зэрэгцээ Хойд Солонгосын хувьд ОХУ нь Евразийн зах зээлд гарах болон түлш ба техник импортлох цорын ганц зам юм. Хойд Солонгос нь эдийн засгийн реформ хийхдээ Хятадын жишээг дагахыг хүсэхгүй байгааг олон янзаар тайлбарладаг авч, энэ улс Хятадын хөрөнгө оруулалт, технологи, зах зээлээс хараат байдал ихсэхээс зайлсхийхийг хичээж байгаа юм.

2011 онд Ким Чен Ир Хятадын зүүн хойд мужуудаар хийсэн танилцах аяллынхаа дараа Улаан-Үдэд айлчлал хийсэн нь БНАСАУ, ОХУ-тай харилцаагаа хөгжүүлэх хүсэлтэй байгаагийн дохио байв.

Хойд Солонгосын сул хөгжилтэй дэд бүтэц нь оросын хөрөнгө оруулалт хийх хамгийн боломжийн салбар юм. Үүнээс хамтын ажиллагааны хамгийн ирээдүйтэй салбар нь дэд бүтцийн төслүүд болох зам, инженерийн сүлжээ, аялал жуулчлал юм.

Оросууд БНАСАУ-ын байгалийн нөөц баялаг, түүний дотор эрдэс бодистой холбоотой ажил хэргийн холбоо тогтоох боломжийг эрэлхийлж байгаа юм. 2014 оны 10 дугаар сард талууд БНАСАУ-ын төмөр замын тогтолцоог шинэчлэх хамтарсан ховор төслийг эхлүүлжээ. Төслийн нөхцөлийн дагуу ОХУ Хойд Солонгосын төмөр замыг боловсронгуй болгоход тусламж үзүүлээд оронд нь Солонгосын эрдэс баялгийн нөөц рүү орох юм. Ийнхүү сүүлийн үед ОХУ ба Хойд Солонгос хоёр нь улс төр, эдийн засгийн харилцаагаа өргөжүүлсээр байна.

ОХУ ба Хойд Солонгост тодорхой хэмжээний геополитикийн ашиг сонирхол, хэрэгцээ байгаа юм. Хойд Солонгос нь ОХУ-ын хувьд уламжлал ёсоор АНУ ба Японоос тусгаарлаж буй стратегийн буфер болсоор байгаа юм. ОХУ болон Хойд Солонгосын түншлэл нь Оросын Өмнөд Солонгос ба Японтой эдийн засгийн асуудлаар, АНУ-тай аюулгүй байдлын асуудлаар (НАТО ба пуужингийн довтолгооноос хамгаалах систем зэрэг) харилцах боломжийг нь нэмэгдүүлж өгч байгаа юм. ОХУ нь Хойд Солонгосын хувьд бол улам бүр өөртөө итгэлтэй, хүчээ авсаар буй Хятадын өмнө улс төр, эдийн засаг, цэргийн дэмжлэг авах цорын ганц эх үүсвэр нь болсоор байгаа юм. Хойд Солонгос үе үеийн гэнэтийн өөрчлөлтүүд гарч байсныг үл харгалзан Оростой тогтоосон урьдынхаа харилцаанд нааштай эерэгээр үнэлэн хандсаар ирсэн. БНАСАУ төрийнхөө институцуудыг Оросын туслалцаатайгаар байгуулж байхад, Оросууд Төв ба Зүүн Европын орнуудад тийм институцийг нураан устгаж байв. Түүнээс гадна, Хойд Солонгос 1991 онд ЗХУ-ын тусламжаар өнөөгийн олон улсын тогтолцооны гишүүн болсон түүхтэй. Үүний зэрэгцээ Хойд Солонгос нь АНУ ба Японтой харилцаагаа албан ёсоор тогтоох эрмэлзэлтэй явж ирсэн.

Өнөө цагт Оросын геостратегийн байр суурийг сэргээх явдал ихээхэн төвөгтэй байгаа бөгөөд АНУ-ыг АНДБН-тай “холбогдуулах”-тай нэлээд төстэй байгаа юм. ОХУ Алс Дорнод дахь цэргийнхээ хүчийг нэмэгдүүлэх боломжтой боловч аюулгүй байдлын салбарт Хойд Солонгостой эрчимтэй харилцаатай байж төдийлөн чадахгүй байгаа юм. Учир нь цэрэг дайны салбарт хийх алхам бүр нь Хятад, Япон, Өмнөд Солонгос зэрэг гол чухал хөрөнгө оруулагчидтайгаа харилцаагаа таслахад хүргэх эрсдэлтэй юм. Үүнээс гадна Оросын талаас хэтэрхий их хүч түрсэн ажиллагаа явуулах аваас БНАСАУ-ыг Хятадтай ойртоход хүргэж болзошгүй юм. Гэвч ОХУ нь Хойд Солонгосын улс төрийн элитүүд болон ард түмэнд хамгийн боломжийн, ойр дотны, ойлгомжтой түнш нь хэвээрээ байх болно. Хойд Солонгос нь ОХУ-ын хувьд урьдын нэгэн адил Зүүн Өмнөд Азийн зах зээлд гарах эдийн

засгийн корридор болон Оросыг эртний өрсөлдөгч нараас нь тусгаарласаар ирсэн стратегийн жийргэвч хэвээр байх юм.

Ийнхүү ОХУ ба Хойд Солонгосын харилцааг дэлхийн геополитикийн хөгжлийн өнөөгийн түвшинд авч үзэж, судалгаа хийх явдал нь АНДБН-ийн орнууд дэлхий дээр асар их үүрэг гүйцэтгэх болсонтой холбоотой юм. ОХУ ба Өмнөд Солонгосын харилцаа сүүлийн үед хөгжих төлөвтэй байна гэж үзвэл Хойд Солонгостой тогтоосон харилцаа нь өнгөцхөн харахад Оросын хувьд “эерэг” зүйл байхгүй мэт санагдаж байж болох юм. Энэ нь зөвхөн өнгөцхөн харахад л шүү дээ. Харин уг асуудлыг гүн рүү нь орж харах юм бол өнөө үед Хойд Солонгос нь Оросын хувьд, бүр цаашлаад Алс Дорнодын хувьд чухал стратегийн түнш нь мөн хэвээр байгаа юм. Үүний гэрч гэвэл, Хойд Солонгос нь ОХУ-ын Алс Дорнодын олон муж, хоттой үйлдвэрлэл, эдийн засгийн хамтын ажиллагаатай байх ихээхэн сонирхолтой байгаа явдал юм. Алс Дорнодын бүс нутгийн аж үйлдвэрийн хувьд Оросын баруун бүсд ойрын ирээдүйд бүтээгдэхүүнээ хүргэх боломжгүй байгаа тул ОХУ-д Хойд Солонгосд бараагаа борлуулах зах зээл хэрэгцээтэй байгаа юм.

Үүнээс гадна Солонгосын хойгтой танилцсан цагаас хойш Өмнөд Солонгос улстай стратегийн түншлэлтэй болоход Орос улс стратегийн асар их үүрэгтэй байсаар ирсэн. Иймээс харилцааныхаа өнөөгийн шатанд ч гэсэн ОХУ бүх талын хамтын ажиллагаа, үүний дотор Хойд Солонгосд ямар ч тусламжийг үзүүлэх, мөн Хойд ба Өмнөд Солонгосыг ойртуулах боломжийн талаар яриа хэлцэл хийлгэхийн төлөө илүү идэвхтэй байхыг эрмэлзсээр байгаа юм.

ДУГНЭЛТ

Ийнхүү ОХУ нь БНАСАУ-тай харилцахдаа урьдын “нэр хүндээ” сэргээж чадвал Оросын Алс Дорнод дахь гадаад бодлогын үр ашигтай байдлын үзүүлэлт болох юм. БНАСАУ нь ОХУ-ын хувьд бараа бүтээгдэхүүнийг нь борлуулах зах зээлд гарах бүс нутаг болохоос гадна бас БНХАУ-ын нэгэн адил ОХУ-ын аюулгүй байдлыг хангахад буфер болж байгаа юм. Сүүлийн үед Хойд Солонгос нь цөмийн зэвсэг болон түүнийг тээвэрлэгч пуужингийн туршилтыг удаа дараа хийсээр байгаа нь “цөмийн хямрал”-д хүргэсээр байгаа нь ОХУ болон БНАСАУ-ын хоорондын худалдаа-эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлэхэд саад болсоор байгаа юм.

Иймээс ОХУ сүүлийн жилүүдэд хямралыг зохицуулахад идэвхтэй үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд уг асуудлыг бүр мөсөн шийдвэрлэн зохицуулахад ОХУ, АНУ, БНАСАУ, БНСУ, БНХАУ, Япон улсын оролцоотой зургаан талт яриа хэлэлцээ чухал гэж үздэг. Оросын талаас Солонгосын хойг дахь асуудлыг зөвхөн улс төр-дипломатын яриа хэлэлцээний аргаар л шийдвэрлэхээс өөр ямар нэгэн хямралыг өдөөн, гааруулсан алхам хийхээс сэрэмжлүүлсээр байгаа юм. Тухайлбал, ОХУ-ын ГХЯ-наас БНАСАУ-ын цөмийн туршилт хийж буйг буруушааж, олон улсын эрх зүйг бүдүүлгээр зөрчихгүй байхыг сануулсаар байна.

НОМ ЗҮЙ

1. Абрамова О. и др. Внешняя политика России: теория и практика. М., “Книга и бизнес”, 2013, 261-р тал.
2. Богатуров А., Аверков В. История международных отношений. 1945-2008. М., “Аспект Пресс”, 2012, 98-р тал.
3. Воронцов А. Россия и Корейский полуостров: современные реалии и перспективы// Проблемы Дальнего Востока. 2002. № 3.
4. Орлов А. и др. История России. М., Проспект, 2015, 605-р тал.
5. Под ред. Ланцова С., Ачкасова В. Мировая политика и международные отношения. СПб., “Питер Пресс”, 2008, 398-р тал.
6. Ткаченко В. Корейский полуостров и интересы России. М., 2000.
7. Енхо Ким. Россия собирается инвестировать в инфраструктуру КНДР. <http://www.golos-ameriki.ru/content/russia-north-korea/2643022.html>, 13.02.2015.